



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/15-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Н.Алтантуяа Утас: 703333019 Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Албан шаардлага	15
4.2 Зөвлөмж.....	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
БНЧУ	Бүгд Найрамдах Чех Улс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ТББ	Төрийн бус байгууллага
ҮЭХ	Үйлдвэрчний эвлэлийн хороо



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ МСҮТ-ИЙН
ЗАХИРАЛ Д.ТУНГАЛАГ ТАНАА

2022.02.25 № 116
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймаг дахь МСҮТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймаг дахь МСҮТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	318,010,888.89	280,158,504.27
33	АВЛАГА	6,606,920.47	371,189.66
33500	Бусад авлага	6,606,920.47	371,189.66
33510	Байгууллагаас авах авлага	6,356,420.47	120,689.66
33520	Хувь хүмүүсээс авах авлага	250,500.00	250,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	311,403,968.42	279,787,314.61
35100	Түүхий эд материал	559,950.00	537,300.00
35130	Эм боох материал	559,950.00	537,300.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,800,200.00	4,800,200.00
35400	Хангамжийн материал	284,972,818.42	254,693,814.61
35410	Бичиг хэргийн материал	828,950.00	658,350.00
35420	Аж ахуйн материал	24,309,347.40	22,313,971.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,942,000.00	10,927,000.00
35450	Барилгын засварын материал	19,163,334.00	14,660,031.00
35460	Хүнсний материал	14,243,000.01	914,500.00
35470	Бусад хангамжийн материал	215,824,187.01	205,219,962.61
35600	Мал амьтад	21,071,000.00	19,756,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,738,493,725.23	6,040,318,662.78
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,738,493,725.23	6,040,318,662.78
39200	Биет хөрөнгө	4,674,632,558.65	4,977,236,662.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,345,621,092.00	3,320,301,092.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-223,834,812.47	-373,684,160.54
39203	Авто-тээврийн хэрэгсэл	491,999,000.00	491,999,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-81,716,136.83	-119,414,763.59
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,444,929,198.95	2,120,834,640.95
39206	Хуримтлагдсан элэгдэл	-543,579,784.55	-698,477,857.20
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	243,703,321.31	257,776,321.31
39208	Хуримтлагдсан элэгдэл	-151,340,874.70	-172,195,040.09
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,793,000.00	20,793,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,930,593.75	-9,704,718.75
39217	Ном	135,989,148.69	139,009,148.69
39300	Биет бус хөрөнгө	1,063,861,166.58	1,063,082,000.00
39301	Програм хангамж	15,325,000.00	15,325,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-14,545,833.42	-15,325,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,063,082,000.00	1,063,082,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,056,504,614.12	6,320,477,167.05
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,056,504,614.12	6,320,477,167.05
51	Засгийн газрын хувь оролцоо	6,056,504,614.12	6,320,477,167.05
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,301,627,386.68	2,301,627,386.68
51200	Хуримтлагдсан үр дүн	131,216,470.55	395,189,023.48
51210	Өмнөх үеийн үр дүн	-524,126,468.56	131,216,470.55
51220	Тайлант үеийн үр дүн	655,342,939.11	263,972,552.93
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,623,660,756.89	3,623,660,756.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,056,504,614.12	6,320,477,167.05

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,389,368,592.35	2,177,390,786.47
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	902,300,192.35	676,051,342.00
120	Нийтлэг татварын бус орлого	902,300,192.35	676,051,342.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,318,442.35	1,540,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	1,540,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,318,442.35	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	802,033,000.00	656,170,042.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	98,948,750.00	18,341,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,487,068,400.00	1,501,339,444.47
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,484,474,400.00	1,434,171,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,484,474,400.00	1,434,171,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,594,000.00	67,167,944.47
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	40,470,244.47
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,594,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	25,897,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,726,623,989.51	1,913,418,233.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,726,623,989.51	1,913,418,233.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,586,687,195.07	1,841,205,851.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	995,728,099.35	1,018,105,549.15
210101	Үндсэн цалин	635,420,599.60	755,709,886.68
210102	Нэмэгдэл	256,613,499.90	189,517,545.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,767,999.90	37,680,659.12
210104	Урамшуулал	60,925,999.95	35,197,457.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,272,968.65	132,276,339.66
210201	Тэтгэврийн даатгал	72,719,034.01	92,527,590.47
210202	Тэтгэмжийн даатгал	7,644,534.64	9,815,418.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,975,900.00	7,716,275.04
210204	Ажилгүйдлийн даатгал	1,993,900.00	1,910,450.97
210205	Эрүүл мэндийн даатгал	19,939,600.00	20,306,604.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,733,517.16	132,141,000.41
210301	Гэрэл, цахилгаан	36,101,917.16	48,998,800.41
210302	Түлш, халаалт	68,581,800.00	82,013,000.00
210303	Цэвэр, бохир ус	5,049,800.00	1,129,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,062,650.00	58,434,573.00
210401	Бичиг хэрэг	2,336,519.00	3,221,780.00
210402	Тээвэр, шатахуун	13,034,300.00	11,061,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,708,800.00	8,591,387.73
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,329,300.00	3,557,230.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,378,731.00	12,906,724.47
210408	Бараа материал акалсны зардал	275,000.00	19,095,850.80
2105	Нормативт зардал	19,545,989.00	35,776,045.81
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	651,000.00	584,120.00
210502	Хоол, хүнс	18,894,989.00	35,191,925.81
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,115,479.00	22,624,910.00

Архангай аймаг дахь МСҮТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,583,570.00	691,900.00
210604	Урсгал засвар	15,531,909.00	21,933,010.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,754,672.00	14,406,426.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	782,580.00	13,050,670.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	347,592.00	550,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	235,000.00	575,356.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	889,500.00	230,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	295,473,819.91	427,441,007.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,500,000.00	11,962,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	32,832,295.00	19,781,503.04
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	255,141,524.91	395,697,104.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	139,936,794.44	72,212,382.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	114,916,985.15	66,723,750.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,985,200.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	99,961,000.00	65,383,750.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,970,785.15	1,340,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,019,809.29	5,488,632.02
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,019,809.29	5,488,561.42
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	70.60
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	662,744,602.84	263,972,552.93
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,401,663.73	
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	7,401,663.73	
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	655,342,939.11	263,972,552.93

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,301,627,386.68	3,623,660,756.89	-525,375,673.48	5,399,912,470.09
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	1,249,204.92	1,249,204.92
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,301,627,386.68	3,623,660,756.89	-524,126,468.56	5,401,161,675.01
4	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	655,342,939.11	655,342,939.11
5	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,301,627,386.68	3,623,660,756.89	131,216,470.55	6,056,504,614.12
6	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,301,627,386.68	3,623,660,756.89	131,216,470.55	6,056,504,614.12
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,301,627,386.68	3,623,660,756.89	131,216,470.55	6,056,504,614.12
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	263,972,552.93	263,972,552.93
10	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,301,627,386.68	3,623,660,756.89	395,189,023.48	6,320,477,167.05

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,489,537,711.00	1,502,879,444.47
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,904,891.00	1,540,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,904,891.00	1,540,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,904,891.00	1,540,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	1,540,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,904,891.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,487,632,820.00	1,501,339,444.47
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,484,474,400.00	1,434,171,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,484,474,400.00	1,434,171,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,158,420.00	67,167,944.47
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	40,470,244.47
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,594,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	564,420.00	25,897,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,488,037,711.00	1,461,527,444.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,488,037,711.00	1,461,527,444.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,348,390,701.71	1,389,369,062.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	995,728,099.35	1,009,978,100.00
210101	Үндсэн цалин	635,420,599.60	715,907,274.68
210102	Нэмэгдэл	256,613,499.90	208,449,229.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,767,999.90	37,455,601.20
210104	Урамшуулал	60,925,999.95	48,165,994.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,399,699.20	134,168,058.00
210201	Тэтгэврийн даатгал	78,150,099.20	93,995,405.91
210202	Тэтгэмжийн даатгал	9,969,800.00	10,067,564.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,346,300.00	8,053,971.95
210204	Ажилгүйдлийн даатгал	1,993,900.00	2,004,719.57
210205	Эрүүл мэндийн даатгал	19,939,600.00	20,046,395.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,183,917.16	125,228,360.41
210301	Гэрэл, цахилгаан	36,101,917.16	48,998,800.41
210302	Түлш, халаалт	76,993,800.00	73,351,000.00
210303	Цэвэр, бохир ус	5,088,200.00	2,878,560.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,670,775.00	27,845,212.20
210401	Бичиг хэрэг	2,432,900.00	2,877,070.00
210402	Тээвэр, шатахуун	12,604,500.00	10,061,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,708,800.00	8,591,387.73
210404	Ном, хэвлэл	0.00	50,244.47
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,575,740.00	3,968,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,348,835.00	2,296,910.00
2105	Нормативт зардал	29,305,249.00	34,234,515.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,139,500.00	576,700.00
210502	Хоол, хүнс	26,099,949.00	32,485,815.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,065,800.00	1,172,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,807,770.00	6,303,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,548,000.00	0.00
210604	Урсгал засвар	2,259,770.00	6,303,400.00

Архангай аймаг дахь МСҮТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,848,792.00	17,748,056.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	876,700.00	14,233,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	347,592.00	550,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	235,000.00	575,356.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	889,500.00	2,389,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,446,400.00	33,863,360.04
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	41,446,400.00	33,863,360.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	139,647,009.29	72,158,382.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	114,627,200.00	66,669,750.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,985,200.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	99,961,000.00	65,329,750.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,681,000.00	1,340,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,019,809.29	5,488,632.02
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,019,809.29	5,488,561.42
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	70.60
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,500,000.00	41,352,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,500,000.00	41,352,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,500,000.00	41,352,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,500,000.00	41,352,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,500,000.00	41,352,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,500,000.00	-41,352,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,445,496,500.00	1,430,222,938.58	15,273,561.42	98.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,445,496,500.00	1,430,222,938.58	15,273,561.42	98.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,378,821,900.00	1,363,553,188.58	15,268,711.42	98.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,009,978,100.00	1,009,978,100.00	0.00	100.0
210101	Үндсэн цалин	715,420,600.00	715,907,274.68	-486,674.68	100.1
210102	Нэмэгдэл	182,113,500.00	208,449,229.80	-26,335,729.80	114.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,768,000.00	37,455,601.20	5,312,398.80	87.6
210104	Урамшуулал	69,676,000.00	48,165,994.32	21,510,005.68	69.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134,592,100.00	134,168,058.00	424,042.00	99.7
210201	Тэтгэврийн даатгал	94,712,900.00	93,995,405.91	717,494.09	99.2
210202	Тэтгэмжийн даатгал	9,969,800.00	10,067,564.95	-97,764.95	101.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,975,800.00	8,053,971.95	-78,171.95	101.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,994,000.00	2,004,719.57	-10,719.57	100.5

Архангай аймаг дахь МСҮТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	19,939,600.00	20,046,395.62	-106,795.62	100.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	127,830,700.00	125,228,360.41	2,602,339.59	98.0
210301	Гэрэл, цахилгаан	51,810,400.00	48,998,800.41	2,811,599.59	94.6
210302	Түлш, халаалт	71,646,100.00	73,351,000.00	-1,704,900.00	102.4
210303	Цэвэр, бохир ус	4,374,200.00	2,878,560.00	1,495,640.00	65.8
2104	Хангамж, бараа материалын зардал	26,451,900.00	25,550,167.73	901,732.27	96.6
210401	Бичиг хэрэг	2,877,100.00	2,877,070.00	30.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	8,276,800.00	7,816,800.00	460,000.00	94.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,268,400.00	8,591,387.73	-322,987.73	103.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,968,000.00	3,968,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,061,600.00	2,296,910.00	764,690.00	75.0
2105	Нормативт зардал	24,386,000.00	18,872,815.80	5,513,184.20	77.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	627,800.00	576,700.00	51,100.00	91.9
210502	Хоол, хүнс	22,585,600.00	17,124,115.80	5,461,484.20	75.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,172,600.00	1,172,000.00	600.00	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,061,800.00	7,235,400.00	826,400.00	89.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,758,400.00	932,000.00	826,400.00	53.0
210604	Урсгал засвар	6,303,400.00	6,303,400.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,406,500.00	13,748,056.00	3,658,444.00	79.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,289,000.00	10,233,200.00	3,055,800.00	77.0
210803	Даатгалын үйлчилгээ	998,000.00	550,000.00	448,000.00	55.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	730,000.00	575,356.00	154,644.00	78.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,389,500.00	2,389,500.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,314,800.00	28,772,230.64	542,569.36	98.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,314,800.00	28,772,230.64	542,569.36	98.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,674,600.00	66,669,750.00	4,850.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	66,674,600.00	66,669,750.00	4,850.00	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	65,329,800.00	65,329,750.00	50.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,344,800.00	1,340,000.00	4,800.00	99.6
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,445,496,500.00	1,430,222,938.58	15,273,561.42	98.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,434,171,500.00	1,428,682,938.58	5,488,561.42	99.6
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,434,171,500.00	1,428,682,938.58	5,488,561.42	99.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	11,325,000.00	1,540,000.00	9,785,000.00	13.6
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,500,000.00	1,540,000.00	7,960,000.00	16.2
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	73	87	-14	119.2
620001	Удирдах ажилтан	2	1	1	50.0
620002	Гүйцэтгэх ажилтан	46	57	-11	123.9
620003	Үйлчлэх ажилтан	25	29	-4	116.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	577	577	0	100.0

Архангай аймаг дахь МСҮТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	577	577	0	100.0
632001	Төрийн өмчит МСҮТ	577.00	577.00	0.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	73.00	73.00	0.00	100.0
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	42.00	42.00	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	31.00	31.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	67,167,873.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	67,167,873.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	67,167,873.87
2104	Хангамж, бараа материалын зардал	5,315,044.47
210402	Тээвэр, шатахуун	2,244,800.00
210404	Ном, хэвлэл	3,070,244.47
2105	Нормативт зардал	15,361,700.00
210502	Хоол, хүнс	15,361,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,400,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,928,000.00
210602	Тавилга	35,472,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,091,129.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,091,129.40
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	67,167,944.47
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	67,167,944.47
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	40,470,244.47
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	25,897,700.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг нормативын дагуу бодож олгох, бараа материалын тайланг нэр төрөл тус бүрээр бэлтгэхтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Алтантуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд заасны дагуу мэргэжлийн боловсрол олгох чиг үүрэг бүхий ХНХЯ-ны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд *“Сургуулийн хөгжлийн төлөвлөлт, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох, мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааны чанарыг тасралтгүй хөгжүүлэх, сургалтын орчин материаллаг баазыг сайжруулах”* гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд аймгийн ХНХЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраас шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хяналт хийсэн байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэнтэй бөгөөд 2021 онд номын сан, архив, дотуур байр, багш ажилчдын хуримтлалын сан, ҮЭХ-ны үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 1,445.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 14.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 10.8 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 264.0 сая төгрөгөөр буюу 4.4 хувиар өсч материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	
Авлага	6.6	0.4	(6.2)	(93.9)
Бараа материал	311.4	279.8	(31.6)	(10.1)
Үндсэн хөрөнгө	5,738.5	6,040.3	301.8	5.3
Нийт хөрөнгө	6,056.5	6,320.5	264.0	4.4
Өр төлбөр	-	-	-	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,056.5	6,320.5	264.0	4.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,056.5	6,320.5	264.0	4.4

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 93.9 хувиар буурсан байна.

Авлагын дансны эхний үлдэгдэл 6.6 сая төгрөг байснаас тайлант онд 6.2 сая төгрөгийн авлага барагдаж, оны эцэст 0.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Бараа материалын үлдэгдэл 10.1 хувиар буурсан байна.

Бараа материалын данс нь 311.4 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 63.5 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 47.6 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 279.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 5.3 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 5,738.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд нэмэлт санхүүжилтээс худалдаж авсан 41.3 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 656.2 сая төгрөг нийт 697.5 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 395.7 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр тус тус буурч, 6,040.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнг 264.0 сая төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,484.5	1,434.2	(50.3)
Нэмэлт санхүүжилтийн орлого	2.6	67.2	64.6
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	901.0	674.5	(226.5)
Төсөвт байгууллагын өөрийн орлого	1.3	1.5	0.2
Үйл ажиллагааны орлого	2,389.4	2,177.4	(212.0)
Цалин, шимтгэлийн зардал	1,106.0	1,150.4	44.4
Бусад бараа үйлчилгээний зардал	181.4	249.0	67.6
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3.8	14.4	10.6
Бараа үйлчилгээний бусад зардал	288.0	427.4	139.4
Урсгал шилжүүлэг	138.7	72.2	(66.5)
Үйл ажиллагааны зардал	1,717.9	1,913.4	195.5
Үйл ажиллагааны бус зардал	14.9	-	(14.9)
Үйл ажиллагааны үр дүн	656.6	264.0	(392.6)

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх урсгал үйл ажиллагааны санхүүжилт өмнөх оноос 50.3 сая төгрөгөөр буюу 3.4 хувиар буурсан байна. Урсгал санхүүжилтээс 5.5 сая төгрөг хэмнэгдэж буцаан төвлөрүүлсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 1,520.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг анх 66.9 сая төгрөгөөр бууруулан 1,453.3 сая төгрөгөөр хянаж баталжээ. Харин төсвийн тодотголоор 7.8 сая төгрөгөөр бууруулан 1,445.5 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 1,445.5 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,434.2 сая төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 1.5 сая төгрөг төвлөрүүлэн нийт 1,435.7 сая төгрөгийн орлого, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлснээс 1,430.2 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 5.5 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь бараа үйлчилгээний зардлуудаас хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтээр Канадын ЭСЯ-ны орон нутгийн сангийн төсөл хөтөлбөрөөс “Цахим номын сан” төслийн санхүүжилт 40.5 сая төгрөг, ХЭДС-аас сургалтын зардалд 5.2 сая төгрөг, аймгийн ЗДТГ-аас цэргийн дүйцүүлэх албаны сургалтай холбоотойгоор 0.8 сая төгрөг, Жэрэс ТББ-аас түрээсийн зардалд 0.8 сая төгрөг, ОБГ-аас хоолны зардалд 15.1 сая төгрөг, автобус акталж, сэлбэг материалыг борлуулсны орлогоор 4.8 сая төгрөг нийт 67.2 сая төгрөгийг тус тус хүлээн авч, тээвэр шатахууны зардалд 2.4 сая төгрөг, ном хэвлэлийн зардалд 3.1 сая төгрөг, хоол хүнсний зардалд 15.4 сая төгрөг, багаж техник хэрэгсэлд 1.9 сая төгрөг, тавилга эд хогшил худалдан авах зардалд 35.5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 4.0 сая төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд 5.1 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус байгууллага нь ХНХЯ-нд хийгдсэн АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 601.9 сая төгрөгийн өртөг бүхий ноос, ноолуур угаах тоног төхөөрөмж, БНЧУ-ын Элчин сайдын яамны орон нутгийн жижиг төслөөс 63.1 сая төгрөгийн өртөг бүхий сүү, сүүн бүтээгдэхүүнийг савлах тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөнд бүртгэж, тайлагнасан байна.

Канад Улсын ЭСЯ-ны дэргэдэх орон нутгийн санаачилга хөтөлбөртэй хамтран “Цахим номын сан” төслийг амжилттай хэрэгжүүлэн нэмэлт санхүүжилтийн дансаар 40.5 сая төгрөгийг хүлээн авч, номын санг тохижуулахад шаардлагатай ном, тавилга эд хогшил болон компьютер тоног төхөөрөмжийг худалдан авчээ.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 3 үндсэн зорилтын хүрээнд 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж,

дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ХНХЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас 94.0 хувь гэж үнэлсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 1,445.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,430.2 сая төгрөгийг зарцуулж, 98.9 хувийн биелэлттэй байна.

Тус байгууллага нь үндсэн үйл ажиллагааны орлогоос 9.5 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1.8 сая төгрөгийг төвдлөрүүлэхээс үндсэн санхүүжилтийн дансаар 1.5 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансаар 10.8 сая төгрөгийг төвлөрүүлэн зарцуулсан байна. Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлснээс шалтгаалан үндсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл дутуу тайлагнагдсан байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаарх судалгааг авч үзэхэд:
 - Батлагдсан төсөвт зардлаас 5.5 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
2. Суудлын автомашин ашиглалтын судалгаа: Тус байгууллага нь нийт 34.0 сая төгрөгийн анхны өртөг бүхий 1 автомашинтай, шатахууны зардалд 1.7 сая төгрөгийг зарцуулсан, орон тооны жолоочийн цалинд 7.9 сая төгрөгийг олгожээ.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 142 мэдээллээс 91 мэдээллийг хугацаанд нь, 51 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж, мэдээллийг хуулинд заасан хугацаанд тогтмол мэдээлж хэвших зөвлөмжийг хүргүүллээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 7.5 % буюу 16.6 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 43-р тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар нярав, эд хариуцагчийн тайлан, малын бүртгэл тооцоог нарийвчлан авч үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, 3.3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэн, 0.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Албан шаардлага

Бараа материалын тайланг хянаж үзэхэд 29 тооны мал амьтдыг нас дэвшүүлэхдээ зах зээлийн үнээс доогуур үнээр үнэлж, 3.3 сая төгрөгөөр бүртгэлд тусгасан зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-т “ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Малыг бүртгэл тооцоог зах зээлийн үнээр бүртгэж, тайлагнах албан шаардлагыг хүргүүллээ.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Дотуур байрны хүүхдийн хоолны зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Дотуур байрны хүүхдийн хоол, хүнсний зарцуулалтыг няравын тайлангаас нэг сурагчид ногдох нормативаар тулган шалгахад нийт 0.4 сая төгрөгийн хоолны зардлыг дутуу тооцож олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Хоолны зардлын норматив тогтоох тухай” 83 дугаар тогтоолын 1-т “Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын

дотуур байранд амьдрах нэг суралцагчийн хоногийн хоолны зардлыг 3000 (гурван мянга) төгрөгөөр тогтоосугай” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг Засгийн газрын 83 дугаар тогтоолын дагуу тооцож, батлагдсан нормативыг мөрдөж ажиллах

Няравын тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нярав, эд хариуцагчийн тайланг хянаж үзэхэд бараа материалын тайланг нэг бүрийн үнэ, нэр төрлөөр батлагдсан загвар маягтын дагуу бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.1 -т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн Сайдын 2017 оны 347 тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар” -ын 3 дугаар зүйлийн 9-т “Бараа материалын тайланг агуулахын нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн Сайдын 2017 оны 347 тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг мөрдөж, няравын тайланг загвар маягтын дагуу нэр төрөл, тоо хэмжээ, нэг бүрийн үнээр бэлтгэн гаргаж, хэвших

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	МСҮТ	3	3.7	0	0	0	0	1	3.3	2	0.4
	Дүн	3	3.7	0	0	0	0	1	3.3	2	0.4
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	МСҮТ	2	16.6	0	0	0	0	1	16.6	1	0
	Дүн	2	16.6	0	0	0	0	1	16.6	1	0
	Нийт дүн	5	20.3	0	0	0	0	2	19.9	3	0.4